



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/34

Дэлгэрхаан сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалт, халдваргүйтгэл, лабораторийн  
шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8, 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн малын өвчлөл, эпизотологийн судалгааг үндэслэн голомтот бүс нутгийн мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах, халдваргүйтгэл, лабораторийн шинжилгээ, тандах ажлыг хариуцсан багтаа мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийн захирал малын эмч нар графикт хугацаанд ажил зохион байгуулсугай.

2.Багийн малчдад урьдчилан мэдэгдэж зар хүргэх, малчдын малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Шаардагдах вакцин эм бэлдмэлийг татан авч мал эмнэлгийн аж ахуй нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангаж, тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавих, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, тарилгын материалыг хугацаанд нь хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Баярмаа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д хариуцуулсугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН



2326910964

